12	Даваасүрэн Делгүен	66 кг	Мөнгө	3000.0
				4800.0

## Жүдо бөхийн багийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн

13	Баасанхүү Уранчимэг	Багаар	Хүрэл	2400.0
14	Менхбаатар Бундмаа		Хүрэл	2400.0
15	Тавхайн Оюунсүрэн		Хүрэл	2400.0
16	Түмэн-Од Баттегс		Хүрэл	2400.0
17	Хишигбат Эрдэнэт-Од		Хүрэл	2400.0
18	Цэдэвсүрэн Мөнхзаяа		Хүрэл	2400.0
19	Хүрэлдорж Батхишиг		Хүрэл	2400.0
20	Шархүү Цэвэлмаа		Хүрэл	2400.0
21	Пүрэвжаргал Нхамдэгд		Хүрэл	2400.0
22	Доржотов Цэрэнханд		Хүрэл	2400.0
				24000.0

## Сумо бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн

23	Рэнцэндорж Гантэгс	85 кг	Алт	3600.0
24	Түмэннаасан Амартувшин	-115 кг	Мөнгө	1800.0
25	Ганхуяг Наранбат	+115 кг	Мөнгө	1800.0
26	Цэдэв Мягмарсүрэн	Үнэмлэхүй	Хүрэл	900.0
27	Сэлэнгэ Энхзаяа	65 кг	Алт	3600.0
28	Ядамдорж Согоо	+65 кг	Мөнгө	1800.0
29	Бааст Батчимэг	Үнэмлэхүй	Хүрэл	900.0
30	Балжинням Бат-Эрдэнэ	50 кг	Мөнгө	1800.0
31	Баярсайхан Оролзод	Багаар	Мөнгө	1800.0
32	Ядамдорж Согоо		Мөнгө	1800.0
33	Сэлэнгэ Энхзаяа		Мөнгө	1800.0
34	Бааст Батчимэг		Мөнгө	1800.0
35	Раднаабазар Очирпүрэв	Багаар	Хүрэл	900.0
36	Ганхуяг Наранбат		Хүрэл	900.0
37	Уламбаяр Бямбажав		Хүрэл	900.0
38	Цэдэв Мягмарсүрэн		Хүрэл	900.0
				27000.0

## Сумо бөхийн дэлхийн залуучуудын аварга шалгаруулалт тэмцээн

39	Баатар Банзрагч	Багаар	Хүрэл	900.0
----	-----------------	--------	-------	-------



## ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2008 он №9 (534)

40	Адъяа Баасандорж		Хүрэл	900.0
41	Дүгээрсүрэн Нацагдорж		Хүрэл	900.0
42	Баярсайхан Занабазар		Хүрэл	900.0
				3600.0
Сумо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн				
43	Раднаабазар Очирпүрэв		Хүрэл	2400.0
44	Ганхуяг Наранбат	Багаар	Хүрэл	2400.0
45	Уламбаяр Бямбажав		Хүрэл	2400.0
46	Цэдэв Мягмарсүрэн		Хүрэл	2400.0
				9600.0
Сумо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн				
47	Цэдэв Мягмарсүрэн	Үнэмлэхүй	Хүрэл	8000.0
48	Уламбаяр Бямбажав	+115 кг	Алт	18000.0
49	Салэнгэ Энхзаяа	65 кг	Хүрэл	2400.0
				28400.0
Сумо бөхийн дэлхийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээн				
50	Баярсайхан Занабазар	80 кг	Мөнгө	1800.0
51	Адъяа Баасандорж	100 кг	Алт	3600.0
				5400.0
Мотоспортын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн				
52	Эрдэнэбилиг Халиунболд	Багаар	Мөнгө	1800.0
53	Болдбаатар Ган-Од	Багаар	Мөнгө	1800.0
				3600.0
Боксын Ази тивийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээн				
54	Цэрэнжав Ганхуяг	57 кг	Хүрэл	1000.0
				1000.0
Боксын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн				
55	Энхбат Бадар-Ууган	54 кг	Мөнгө	15000.0
				15000.0
Буудлагын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн				
56	Цогбадрах Мөнхзул	25 метр	Мөнгө	6000.0
				6000.0
Буудлагын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн				
57	Отряд Гүндэгмаа	Гар бүү багаар	Мөнгө	1800.0
58	Даваажанцан Оюун		Мөнгө	1800.0
59	Цогбадрах Мөнхзул		Мөнгө	1800.0



60	Зоригт Батхуяг	Урт буу Багаар	Хүрэл	900.0
61	Дамдинсүрэн Лхамсүрэн		Хүрэл	900.0
62	Чулуунбадрах Нарантуяа		Хүрэл	900.0
				8100.0
Буудлагын Ази тивийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээн				
63	Цагаандалай Хонгорзуул	Гар буу Багаар (25 метр)	Менгэ	900.0
64	Төмөрчөдөр Баярцэцэг		Менгэ	900.0
65	Бямбаа Агиймаа		Менгэ	900.0
66	Цагаандалай Хонгорзуул	Гар буу Багаар (10 метр)	Хүрэл	300.0
67	Бямбаа Агиймаа		Хүрэл	300.0
68	Төмөрчөдөр Баярцэцэг		Хүрэл	300.0
				3600.0
		ДҮН		180200.0

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 12 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 358

Улаанбаатар  
хот

## Журам батлах тухай

Агаарын зайл нисэхэд ашиглах тухай хуулийн 5.1-д заасныг ундэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Агаарын зайл нисэхэд ашиглах ерөнхий журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд

Ж.Батхуяг, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Раш нарт тус тус үүргэ болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД

Ж.БАТХУЯГ

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Р.РАШ

Засгийн газрын 2007 оны 358 дугаар  
тогтооолын хавсралт

**АГААРЫН ЗАЙГ НИСЭХЭД АШИГЛАХ  
ЕРӨНХИЙ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1. Монгол Улсын агаарын зайн ангиллыг тогтоох, түүний ашиглалтад зохицуулалт хийх, агаарын зайн хяналт, аюулгүй байдлыг хангуулах, агаарын зайл хүмүүнлэгийн олон улсын үйл ажиллагаанд зориулан ашиглуулах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмыг Монгол Улсын агаарын зайл ашиглаж байгаа улсын болон иргэний нисэхийн байгууллага уйл ажиллагаанд даагаж мөрднене.

**Хоёр. Агаарын зайн ангилал**

2.1. Монгол Улсын агаарын зайл ашиглах зориулалтаар нь улсын болон иргэний нисэхэд ашиглах агаарын зайл гэж тогтооно.

2.2. Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлал нь Иргэний нисэхийн ерөнхий газартай хамтран аюултай, хязгаарлалттай, хориотой болон цэргийн зориулалтын бүсийг тогтооно.

2.3. Цэргийн зориулалтын агаарын бүсийг ашиглалтын төвлөвлөлтийг Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлал Иргэний нисэхийн ерөнхий газарт урьдчилсан мэдэгдэнэ. Тухай агаарын бүсийг иргэний нисэхэд ашиглах тохиолдолд Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалын зөвшөөрлийг авна.

2.4. Аюул тулгарсан агаарын хөлгийн нислэгт цэргийн зориулалтын агаарын бүсийг



ашиглах шаардлага гарах тохиолдолд Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалаас зөвшөөрөл авна.

2.5. Энэхүү журмын 2.3, 2.4-т зааснаас бусад тохиолдолд цэргийн зориулалтын агаарын бүсийг иргэний нисэхэд ашиглахыг хориглоно.

2.6. Иргэний нисэхийн еренхий газартай зөвшлийвэгүй бол иргэний нисэхэд ашиглах агаарын зайд сургууль-байлдааны нислэг хийхийг хориглоно.

2.7. Агаарын хаалга болон агаарын зам нь нэр, дугаартай байна.

#### Гурав. Агаарын зайн хяналт

3.1. Монгол Улсын агаарын зайд үйлдвэрлэж байгаа бүх агаарын хөлгийн нислэгийн төлөвлөлт, хеделгээн, удирдлага нь холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг агаарын зайн хяналтаар тодорхойлно.

3.2. Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах хяналтыг Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлал, нисэхийн аюулгүй ажиллагааг хангах хяналтыг Иргэний нисэхийн еренхий газар холбогдох журмын дагуу тус тус гүйцэтгэнэ.

3.3. Иргэний нисэхийн еренхий газраас хэрэгжүүлэх агаарын зайн хяналт нь агаарын хөлгийн байрлалыг тодорхойлох, агаарын хөлгүүд хоорондын аюулгүйн зайлт хангуулах, нислэгийн хеделгэвийнг хянах, нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах, нислэгийн зөрчлийг илрүүлж таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.

3.4. Агаарын хөлгийн эзэмшигч радиолокацийн ялган таних төхөөрөмжийр тоноглогдоогүй агаарын хөлгөөр нислэг үйлдэх тохиолдолд энэ тухай нислэгийн төлөвлөгөөнд урьдчилан зааж, Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалд мэдэгдэнэ.

#### Дөрөв. Агаарын зайн аюулгүй байдал

4.1. Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ нь үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, нисэхийн аюулгүй ажиллагааг хангахад чиглэгдэнэ.

4.2. Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлал болон Иргэний нисэхийн еренхий газар нь агаарын зайн аюулгүй байдлыг хангах түвшинд шаардлагатай тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчинтэй байна.

4.3. Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлал нь агаарын зайн аюулгүй байдлыг хангах зорилгоор улсын болон иргэний агаарын хөлгийн нислэгийн хеделгэвийн мэдээлэл солилцох, зөрчил гаргасан агаарын хөлгийн нислэгийг таслан зогсоох үйл ажиллагааг зохицуулах журмыг Иргэний нисэхийн еренхий газартай хамтран баталж мэрдэнэ.

4.4. Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдлын зөрчлийг арилгах арга хэмжээг улсын болон иргэний нисэхийн байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

#### Тав. Агаарын зайн ашиглалтын зохицуулалт

5.1. Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлал нь агаарын зайн аюулгүй байдлыг хангах болон батлан хамгаалах зохицуулалтыг гүйцэтгэнэ.

5.2. Иргэний нисэхийн еренхий газар нь агаарын зайд нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулах болон улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор агаарын зайлт үр өвөөжтэй ашиглах зохицуулалтыг гүйцэтгэнэ.

5.3. Монгол Улсын агаарын хилийн бүсийн ашиглалтын зохицуулалтыг Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлал Иргэний нисэхийн еренхий газартай хамтран гүйцэтгэнэ.

#### Зургаа. Монгол Улсын агаарын зайлт хүмүүнлэгийн олон улсын үйл ажиллагаанд зориулсан ашиглуулах

6.1. Монгол Улсын агаарын зайлт хүмүүнлэгийн олон улсын үйл ажиллагаанд зориулсан ашиглуулахыг Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

6.2. Агаарын зайлт хүмүүнлэгийн олон улсын үйл ажиллагаанд зориулсан ашиглуулах асуудлыг Батлан хамгаалахын сайд, Зам, тээвэр, аялаа жуулчлалын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан журмаар зохицуулна.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр  
сарын 04-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар  
хот

### Иргэний бүртгэлийг сайжруулах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүн амын ерхийн болон хаягийн бүртгэл, сонгочийн нэрийн жагсаалтыг шинчилэн гаргаж, илэрсэн зерчлийг арилгах арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт, эдгээр жагсаалтыг 2008 оны 3 дугаар сарын 1-ний дотор Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхэд шаардлагадаа техник хэрэгслийн, программ хангамж худалдан авах, сургалт, сурталчилгаа явуулах, хороодод нэмж ажиллуулах 163 гэрээтийн урамшуулалт зарцуулах 540, 227, 605 (таван зуун дечин сая хоёр зуун хорин долоон мянга зургаан зуун таван) төгрөгийг Засгийн газрын нийц сангаас гаргахыг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр албан бус хаяг (задгай)-т оршин сугваа ерхийг хаягжуулах ажлыг батлагдсан төсөөтөө багтаан 2008 оны 2 дугаар сарын 20-ны дотор зохион Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, уг ажлыг зохион байгуулах аргачлал боловсруулж мэrdүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Менх-Оргил, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболд нарт тус тус даалгасугай.

4. Хүн амын ерхийн болон хаягийн бүртгэл, сонгочийн нэрийн жагсаалтыг гаргах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, иргэний бүртгэлтэй холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж 2008 оны 1 дүгээр сард Засгийн газарт оруулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Менх-Оргилд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРОНХИЙ САЙД

С.БАЯР

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТОД  
ХЭРГИЙН САЙД

Ц.МОНХ-ОРГИЛ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

### Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Териийн албаны тухай хуулийн 17.12.7 заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

бичгийн даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРОНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар  
хот

### Мянганы сорилтын гэрээний хэрэгжилтийн бэлтгэл ажлын тухай

Териийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хэрэгжүүлж байгаа АНУ-ын Засгийн газар хооронд байгуулсан "Мянганы сорилтын гэрээ"-г хэрэгжүүлэх зорилгоор "Монголын мянганы сорилтын сан"-г байгуулж, "Монголын мянганы сорилтын сан"-гийн Удирдах зөвлөлийн

1. Монгол Улсын Засгийн газар, Мянганы сорилтын корпорациар дамжуулан үйл ажиллагаа



бүрэлдэхүүний саналын эрхтэй гишүүдийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Монголын мянганы сорилтын сан"-гийн Удирдах зөвлөлийн анхдугаар хураадааны эхийн байгуулж "Мянганы сорилтын гарзээ"-ний салшгүй хэсэг болох Хавсралтын 1-ийн "Е" хэсгийн 2-т

зассан эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Удирдах зөвлөнд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**САГИЙН САЙД**

Ч.УЛААН

Засгийн газрын 2008 оны 08 дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН  
САН"-ГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Саналын эрхтэй:

Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр

Гишүүд: -Сангийн сайд Ч.Улаан;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа;

-Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ;

-Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолモン;

-Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Раш;

-Монголын үйлдвэрчний звлэлийн холбооны ерөнхийлгэч С.Ганбаатар (тохиролцсоноор);

-Хүний эрх, хөгжлийн төвийн тэргүүн Г.Уранцож (тохиролцсоноор);

-Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар (тохиролцсоноор);

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2008 оны 01 дүгээр  
сарын 19-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар  
хот

**Ажлаас чөлөөлөх тухай**

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Гаалийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Гаргасан хүснэгтийг нь үндэслэн Баагаагийн Баттемерийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-

Улсын гаалийн ерөнхий газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** Н.ЭНХБОЛД

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2008 оны 01 дүгээр  
сарын 19-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар  
хот

**Ажилд томилох тухай**

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Гаалийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дэржээгийн Цэвээнжавыг Засгийн газрын

хэрэгжүүлэгч агентлаг-Улсын гаалийн ерөнхий газрын даргаар тур томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** Н.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр  
сарын 23-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар  
хотТэмдэглэлт өдөр бий  
болгох тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өвдүүдийн тухай хуулийн 5.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 163 дугаар тогтоолоор баталсан

"Тэмдэглэлт өвдүүд"-ийн жагсаалтад "51. Иргэний ниймийн өдөр-1 дүгээр сарын 31." гэж нэмсүтэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008 оны 02 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

Улсын Их Хурал Онцгой албан татварын тухай хуульд  
өөрчлөлт оруулах тухай хууль батлахдаа Үндсэн хуулийн  
холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг  
хянан шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Цэцийн гишүүн Ж.Амарсаная, Ц.Сарантуяа /илтгэгч/, Д.Мөнхзэрэл, Б.Пүрэвням нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Энхзаяа, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөвлөгөөн Улсын Их Хурлын гишүүн Л.Пүрэвдорж, гэрчээр Хууль зүй, Дотоод хэргийн дэд сайд М.Төрбаяр, Хүнс, Хөдөө ах ахуйн дэд сайд Н.Ганбямба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболд нар оролцлоо.

Цэцийн дунд суудлын хуралдаанаар Улсын Их Хурлаас 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль нь Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалтыг зөрчих батлагдсан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Энхзаяа Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан "Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын мөн" гэсэн заалтыг зөрчиж батлагдсан байна. Үндсэн хуулийн энз заалтаар бол Улсын Их Хуралын хуулиар тогтоосон журмыг ягштал билүүлэх ёстойг тунхагласан. Гэтэл Улсын Их Хурал Үндсэн хуулийн "хууль дээдлэх" зарчмыг зөрчиж "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай" болон "Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай" хуулиудын тодорхой зүйл заалтуудыг үл хэрэгсэн маргаж буй хуулийн төслийг авч хэлэлцэж баталсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4-т "Улсын Их Хурлын ...үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооноо", Хорин доддугаар зүйлийн 1-д "Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ" гэж тус тус заасан байдаг.



Энэ нь Улсын Их Хурлын үйл ажиллаганы журмын нэг болох "хууль тогтоох" онцгой бүрэн эрхээ Улсын Их Хурал вөрөө хэрхэн, яаж эдлэхийг хуулиар тогтоох учиртайг тодорхойлж егч байна гэсэн уг. Гэтэл Улсын Их Хурал дээрх журмыг тогтоосон "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-ийн "...Улсын Их Хурлын гишүүн нь санаачилж буй хуулийн төслийнхөө талаар Засгийн газрын, түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагын санал, дүгнэлтийг авсан байх", 18 дугаар зүйлийн 18.10-ын "Улсын Их Хурлын гишүүн энэ хуулийн 3.1.4-т заасны дагуу Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад хуулийн төслийн явуулна", 18.11-ийн "Засгийн газар энэ хуулийн 13.10-т заасан төслийг хуралдаанаараа хэлэлцэн санал дүгнэлтээ 30 хоногт багтаан хууль санаачлагчид хүргүүлэх...", 18 дугаар зүйлийн 18.14-т "Энэ хуулийн 18.1-д заасан хугацаанд Засгийн газар хариу ирүүлээгүй бол тусгайлан өвх саналгүй гэж үзнэ" мөн хуулийн "Хуулийн төсөл өргөн мэдүүлэх" 20 дугаар зүйлийн 20.3.5-ын "Засгийн газар, холбогдох бусад байгууллагын санал дүгнэлт..."-ийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа хуулийн төсөлд хавсаргах ёстойг хуульчилсан заалтуудыг зөрчсөн. Түүнчлэн "Монгол Улсын Их Хурлын тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-ийн "Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхээ гагцхүү чуулганы хэрэгжүүлэх бөгөөд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааныг бэлтгэн явуулах, хуралдаанаар хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, бусад асуудал хэлэлцэх санал хураалгах, батлах, шийдвэр гаргахад Улсын Их Хурлын хуралдааны дэгийг баримтлана" гэсэн заалт, "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай" хуулийн 16 дугаар зүйлд заасан "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл хэлэлцэх журам" болон 18 дугаар зүйлийн 18.1-ийн "Өргөн мэдүүлсэн төслийг Улсын Их Хурлын дарга холбогдох байнгын хороонд шилжүүлэх бөгөөд уг хороо төслийг хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал дүгнэлт гаргах нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бүх ажлыг хариуцна" 18.2-ын "Энэ хуулийн уг төслийг Байнгын хорооны

хуралдаанаар хэлэлцэж эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө холбогдох Байнгын хороо нийт гишүүдэд хувилж хүргүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчиж, хэлэлцүүлгийн явцад зарим гишүүд сануулсаар байсан атал Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн өргөн барьсан хуулийн төслийг хэлэлцэж баталснаараа Монгол Улсын Үндсэн Хуулийн дээрх 2 заалтыг зөрчлөө.

Нэгэнт ингэж Үндсэн хууль зөрчиж батлагдсан хууль нь вөрөө бухлээрээ Үндсэн хуульд харшилсан хууль болох ёстой. Үүгээрээ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-ын "...хууль дээлдэх нь төрийн үйл ажиллагавны Үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 11 дугаар сарын 30-ны өдөр баталсан "Онцгой албан татварын тухай" хуульд верчлэлт оруулах тухай" хууль зөрчсөн байгаа тул түүнийг хүчингүй болгуулахаар энэхүү гомдолоо гаралза.

Маргаж буй хуулийн төслийг хэлэлцэх үеийн материалтай танилцаж байхад энэ асуудлаар хуульд заасан нехцел журмын дагуу Улсын Их Хурлын гишүүд ямар нэгэн үйлдэл хийгээгүй, энэ асуудлаар Монгол Улсын Засгийн газар байр сууриа илэрхийлж, саналдаа Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцээгүй учир өргөн мэдүүлсэн хуульд хавсаргах ёстой холбогдох материалууд нь ч байхгүй байгаагаас гадна Монгол Улсын Их Хурал 2007 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн чуулганын нэгэнт хэлэлцэн баталсан хуульд нехж материалын бүрдүүлэх ажил зохион байгуулж байгаа нь Хууль зүй. Дотоод хэргийн сайдын 2007 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 1/3137, Хүнс, Хөдөө аж ахуйн сайдын 2007 оны 12 дугаар сарын 21-ний 1/2714 тоот албан бичгүүдээс тодорхой харагдаж байна.

Энэ бүхэнд үндэслэж Үндсэн хуулийн тодорхой заалт зөрчиж Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 11 дугаар сарын 30-ны өдөр баталсан "Онцгой албан татварын тухай" хуульд верчлэлт оруулах тухай" Монгол Улсын хуулийг хүчингүй болгох өгнө үү" гэжээ.

**Хоёр. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн**



Л.Пүрэвдорж Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбартаа:

"1. Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх явцад төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр онцгой албан татварын хэмжээг вөрчлөх асуудлаар санал хураан шийдвэрлэсэн бөгөөд үүнтэйгээ уялдуулан Монгол Улсын Их Хурлын чуулгана хуралдааны дэгийн тухай хуульд "төслийн анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь бусад хуулийн заалттай зөрчилдөл Байнгын хороо эсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ холбогдох бусад хуульд нэмэлт, вөрчлөлт оруулах хуулийн төслийг хамтад нь хэлэлцүүлж болно" гэсний дагуу Л.Пүрэвдорж, Г.Занданшатар, Н.Батбаяр нарын Улсын Их Хурлын 15 гишүүн Онцгой албан татварын тухай хуульд вөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн юм.

Хууль санаачлагчид Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, журмын тухай хуулийн 18.11-д заасан Засгийн газрын саналыг авахаар мөн хуулийн 18.10-д заасны дагуу 2007.11.28-ны едрийн 10/7115 тоот бичгээр хуулийн төслийг хүргүүлсэн бөгөөд, Засгийн газар 2007 оны 11 дүгээр сарын 28-ны едер хуралдаж Улсын Их Хурлын гишүүн Л.Пүрэвдорж нарын санаачлан боловсруулсан Онцгой албан татварын тухай хууль, мөн зарим хуульд нэмэлт, вөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн, 2007 оны 11 дүгээр сарын 29-ний едрийн ХЭГ/2402 тоот албан бичгээрээ Засгийн газрын нэгдсэн саналаа хууль санаачлагчид хүргүүлжээ. Хууль санаачлагч нар Онцгой албан татварын хуульд вөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, мөн зарим хуульд нэмэлт, вөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2007 оны 11 дүгээр сарын 29-ний едер Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн байна.

Улсын Их Хуралд Улсын Их Хурлын гишүүн Л.Пүрэвдорж, Н.Батбаяр нарын 15 гишүүний санаачилсан Онцгой албан татварын тухай хуульд вөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн

мэдүүлгэдэж, түүнийг хэлэлцэн баталсан бөгөөд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын болон Хүнс, хөдөө аж ахуйн сайдын албан бичгүүд нь Ц.Дамиран, А.Бакий, Р.Буд, Ч.Содномцэрэн нарын санаачлагчаар боловсруулж байсан Онцгой албан татварын хуулийн төсөлд хамаараа бичгүүд байна.

Иймд Онцгой албан татварын тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхдээ Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 3.1.4, 16 дугаар зүйл, 18.10, 18.11, 18.14, 20.3.5-д заасныг зөрчөөгүй гэж үзэж байна.

Дээр дурдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.5 дахь хэсэгт заасан "төслийн анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь бусад хуулийн заалттай зөрчилдөл Байнгын хороо эсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ холбогдох бусад хуульд нэмэлт, вөрчлөлт оруулах хуулийн төслийг хамтад нь хэлэлцүүлж болно" гэж заасны дагуу Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгтэй хамтад нь хэлэлцүүлэх үүднээс Төсвийн байнгын хороо Онцгой албан татварын тухай хуульд вөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2007 оны 11 дүгээр сарын 29-ний едрийн хуралдаанаархаа хэлэлцэн бөгөөд улмаар мөн хуулийн 16.3 дахь хэсэгт заасны дагуу 2007 оны 11 дүгээр сарын 30-ны едер анхны хэлэлцүүлгээр нь баталсан юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.5 дахь хэсэг нь аливаа хуулийн төслийг хэлэлцэх явцад дэмжигдсэн санал, бусад хуультай зөрчилдөл холбогдох хуульд нэмэлт, вөрчлөлт оруулах хуулийн төслийг хуулийн уялдаа холбоог хангах, бусад хуультай зөрчилдсэн хууль батлахгүй байх шаардлагын үүднээс эхний хуулийн төсөлтэй хамт хэлэлцүүлж, батлах асуудлыг зохицуулсан байдал.

Түүнчлэн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 33.5-д заасны дагуу Монгол Улсын төсвийн тухай хуулийг өмнөх оны 12 дугаар сарын 1-ний дотор багтаан баталдаг тул Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулийг 2007



оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталж, ингэхдээ хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналын дагуу Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт хэлэлцүүлэн батлуулсан байх тул Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн, батлахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16.1, 18.1, 18.2 дахь хэсгийг зөрьеөгүй гэж үзэж байна.

Иймээс Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэн батлахдаа Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг зөрьеөгүй болно" гэжээ.

**Гурав. Хууль зүй, Дотоод хэргийн дэд сайд М.Төрбаяр Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд гэрчээр оролцож гаргасан тодорхойлолтдоо:**

"...2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 8/7019 тоот албан бичгээр Ц.Дамиран гишүүний бланкаар нэр бүхий 4 гишүүн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын санал, дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн. Хуулийн дагуу эхлээд энэ тоотоороо Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хандсан байгаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар манай яаманд хандсан... Хуулийн төсөлд яамдаас санал аваад манай санал, дүгнэлт боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлдэг журамтай. Тэр дагуу яамдад албан тоот явуулсан нь энд дурьдагдсан 1/3137 тоот ч түүний нэг байгаа юм. Ц.Ганхуяг гишүүний хариу ирүүлсэн тоот нь болохоор энэ 4 гишүүний санаачилсан хуулийн төсөлд санал ирүүлсэн 1/2714 тоот байгаа. Тэгэхээр энэ нь Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар нэр бүхий 4 гишүүний санаачилсан хуулийн төсөлд манай яамнаас явуулсан албан тоотын дагуу Хүнс, хедее аж ахуйн яамнаас ирүүлсэн хариу юм. Ганцхан Хүнс, хедее аж ахуйн яам биш энд бүх яамдуудаас санал ирүүлсэн байгаа.

2008 оны төсвийн тодотгол хэлэлцүүлэхтэй холбогдуулаад нэр бүхий 7 хуулийг Л.Пүрэвдорж гишүүний албан бланкан дээр Засгийн газраас санал аваахаар ирүүлсэн. Түүн дотор дахиад Онцгой албан татварын хууль явж байсан. Энэ хуулийн бичлэг нь өөр, санаачлагчид нь бас өөр. Хоёр өөр хуулийн төсөл байгаа юм. Өөрөөр хэлбэл цаг хугацааны хувьд хойно урдаа гараад явж байсан гэсэн уг. Агуулга нь бол адилхан.

**Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж санал дүгнэлт гарсан төсөл нь Л.Пүрэвдорж гишүүний тайлбарлаад байгаа нэр бүхий 7 хууль дотор явж байгаа төсөл юм. Манайх яамдаас санал аваад санал, дүгнэлт гаргаж байх шатанд энэ төсөл нь түрүүлээд батлагдчихсан болохоор дахиж эхнийхээр Засгийн газрын хуралдаан хийж хэлэлцүүлэх шаардлагагүй юм. Санал, дүгнэлт бэлтгэж байх явцад түрүүлээд батлагдчихлаа гээд энэ асуудлыг картаар хаасан.**

**Өргөдөл гаргагч хоёр дахь хуулийн төсөл буюу багцаараа явж байгаа хуулийн төсөлд нөхөж санал аваад байна гэж ойлгоод байна. Яамдаас нөхөн санал авсан юм өрөөсвөө байхгүй. Эхний хуулийн төсөл дээр санал аваа процесст яамдуудад янз бүрийн хугацаанд явагдаж байсан байгаа юм.**

**Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэж санал, дүгнэлт гарсан хуулийн төсөл нь бол сүүлд нэр бүхий 15 гишүүний санаачилсан 7 багц хууль юм. Энэ төсөл нь 11 дүгээр сарын 28-ны хуралдаанаар хэлэлцэгдээд 58 дугаар тэмдэглэл гараад 11 дүгээр сарын 29-нд Улсын Их Хуралд хүргэгдсэн." гэв.**

**Дөрөв. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболд Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд гэрчээр оролцож гаргасан тодорхойлолтдоо:**

"Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Л.Пүрэвдорж нарын санаачилж боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн. Энэ үеэр нилээд олон хууль хамт хэлэлцэгдсэн. Яагаад олон хууль нэг дор



хэлэлцэгдсэн бэ гэхээр Монгол улсын төсөв батлагдах хугацаа тулсан байсан учраас төсөвтэй холбогдуулж зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг Улсын Их Хурлын гишиг санаачлаад, яаралтай хэлэлцэж өгөвч гэж хүсэлт тавьж Засгийн газарт хандаад тэр асуудлуудыг хэлэлцэний дотор Онцгой албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байсан.

Монгол улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх явцад Улсын Их Хурлын ажлын хэсгээс боловсруулсан хуулийн төслийд зарчмын хувьд дэмжиж байна гэдгээ Засгийн газар албан ёсоор илэрхийлсэн. Энэ дотор Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль орж байгаа. Улсын Их Хурал 2008 оны Монгол улсын төсвийн төслийг хуулиар тогтоосон хугацаанд хэлэлцэн батлахад Засгийн газраас бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлэх болно гэдгээ тэмдэглэнд мэн тусгаж өгсөн.” гэв.

#### ҮНДЭСЛЭЛ:

1. Улсын Их Хурлаар 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж Засгийн газрын санал авсан болох нь Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад тэрчүүдийн мэдүүлэг, бусад нотлох баримтвар тогтоогдож байна.

2. Монгол Улсын Их Хурал 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын мөн”, Хорин тавдугаар зүйлийн 4 дахь хэсгийн “Улсын Их Хурлын ...үйл ажиллагааны журмыг хуулиар

тогтооно”, Хорин додлугаар зүйлийн 1 дахь хэсгийн “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Улсын Их Хурал хууль тогтоох онцгой бүхэн эрхээ хэрэгжүүлэхдээ Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хэм хэмжээг ягштал баримталж ажиллах нь зүйтэй болох нь маргтан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад харагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурал 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 4 дахь хэсэг, Хорин додлугаар зүйлийн 1 дахь хэсгийн заалтуудыг тус тус зөрчеэгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг 2008 оны хаврын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор багтаан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**ГИШҮҮД**

**Н.ЖАНЦАН**

**Ж.АМАРСАНАА  
Ц.САРАНТУЯА  
Д.МОНХГЭРЭЛ  
Б.ПҮРЭВНЯМ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар - 12  
Төрийн ордон

№ 265958  
Индекс: 14003

№ 329487

Хэвлэлийн хуудас 3.5